

**УЛСЫН ИХ ХУРЛААС БАТАЛСАН
 ”ОЙ, МОД БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ СЭРГЭЭХ,
 ТУХАЙН ЧИГЛЭЛЭЭР БАЙГУУЛАГДСАН ТОСГОНЫ ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР
 ЭРХЛЭЛТ, НИЙГМИЙН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
 ХӨТӨЛБӨР”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХИЙСЭН
 ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/2009 оны жилийн эцсийн байдлаар/

2010.03.20

Д.д	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл	
1	ЗГ-ын тогтоолын дугаар, огноо	Хөтөлбөрийг УИХ-ын 2000.04.14-ний өдрийн 30 дугаар тогтоолоор баталсан.	
2	Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа	2000-2010 он	
3	Хөтөлбөрийн зорилго	Хөтөлбөрийн зорилго нь ой, мод боловсруулах салбарын үйлдвэрлэлийг сэргээх, тухайн чиглэлээр байгуулагдсан тосгоны хүн амын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн асуудлыг сайжруулахад чиглэнэ. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд тэргүүн ээлжинд мод бэлтгэх, боловсруулах аж ахуйн нэгжийг түшиглэн байгуулагдсан Бугант, Хялганат, Тосонцэнгэл, Түнхэл, Дулаанхаан, Батширээт, Эрээн зэрэг тосгон хамаарна.	
4	Хөтөлбөрийн зорилтууд /үе шатаар/	Зорилтууд	Хөтөлбөрийн зорилгыг хангахын тулд дараахь зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд: 1. Ой, мод боловсруулах үйлдвэрлэлийг сэргээх, хүн амын өргөн хэрэглээний уламжлалт модон эдлэлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх; 2. Ойн санг аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр эзэмшүүлэн ашиглуулж ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээг нэмэгдүүлэх, ойн төрөл бүрийн дагалт баялгийг ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэх; 3. Модны үйлдвэрлэлийн чиглэлийн аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байсан хүмүүсийг газар тариалан, мал аж ахуй эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх, бусад үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх үйл ажиллагааг дэмжих; 4. Тосгоны хүн амын нийгмийн асуудлыг сайжруулахад нь дэмжлэг үзүүлэх.
		Нэгдүгээр үе шат 2000-2005 он	1. Нутгийн захиргааны байгууллага хөтөлбөрт заасан ажлын байрыг нэмэгдүүлэх боломжит эх сурвалжийг судалж, иргэдийг ажлаар хангах асуудлыг хэрэгжүүлэх арга хэмжээ авна. 2. өрийн захиргааны төв байгууллага ой, модны үйлдвэрлэлийг сэргээх бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлж эхэлнэ. 3. Аж ахуйн нэгж, байгууллагад ойг гэрээгээр эзэмшүүлж ашиглуулах, хамгаалах, ойн сангийн баялгийг зөв зохистой ашиглах асуудлыг шийдвэрлэнэ.
		Хоёрдугаар үе шат 2006-2010	Ой, мод боловсруулах салбарын аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг сэргээж, төлөвлөгдсөн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлнэ.
5	Зарцуулсан хөрөнгө	Төсөв /шаардагдах нийт зардал/	Жижиг төслүүдийн зориулалтаар улсын төсвөөс 120.0 сая төгрөг, бусад эх үүсвэрээс 420.0 сая төгрөгийн зээл олгохоор төлөвлөжээ.
		Гүйцэтгэл /өссөн дүнгээр/	Улсын төсвөөс 2165.0 мянган төгрөг, Хөдөлмөр эрхлэлтийн сангаас 70 сая, Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас 45 сая төгрөгийн зээл олгосон, тэрчлэн арилжааны банкуудаас 265.6 сая төгрөгийн зээл авчээ.

			2008 онд нийт 75.6 сая төг. Үүнээс банкны зээл 65.6 (Түнхэл 45, Бугант 18.3, Дулаанхаан 11.5, Батширээт 2.3) сая төг. ШУТСангаас 10.0 сая төг./									
		<i>тухайн жилд зарцуулсан</i>	Улсын төсвөөс 2165.0 мянган төгрөг									
6	<i>Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ</i>	<i>Биелэлтийн хувь</i>	<i>Нийт</i>	<i>100</i>	<i>90</i>	<i>70</i>	<i>50</i>	<i>40</i>	<i>30</i>	<i>10</i>	<i>Дундаж</i>	
		<i>I шатны 2000-2005 оны зорилт</i>	4									93 %
		<i>II шат 2006-2010 оны зорилт</i>	4		1	3						75 %
7	<i>Шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл</i>	<i>Төлөвлөсөн</i>		<i>Гүйцэтгэл</i>								
		<p>- Ой, модны аж ахуйн нэгжийг түшиглэн байгуулагдсан тосгоны хүн амын хөдөлмөр эрхлэлт сайжирч, ажлын байр нэмэгдэнэ;</p> <p>- Бугант, Хялганат, Тосонцэнгэл, Түнхэл, Дулаанхаан, Батширээт, Эрээн тосгон, бусад аймаг, хотын иргэд, байгууллагуудын хоорондын уялдаа холбоо сайжирч, үйлдвэрлэл, худалдаа өргөжнө;</p> <p>- Тосгоны хүн амын амьжиргааны төвшин дээшилж, ой модны аж ахуйн нэгжүүдэд ажиллаж байсан хүмүүс шинэ мэргэжил ажлын байртай болж, тэдний өрхийн орлого нэмэгдэнэ.</p>		<p>- 2006 онд Түнхэл тосгонд 80, Дулаанхаан тосгонд 105, 2007 онд Бугант тосгонд 125, Түнхэл тосгонд 33, Дулаанхаан тосгонд 18, 2008 онд Бугант тосгонд 160, Түнхэл тосгонд 520 ажлын байрыг бий болгосон.</p> <p>- 2009 оны жилийн эцсийн байдлаар Завханы Тосонцэнгэлд ойжуулалт, ойн арчилгаа, цэвэрлэгээ, мод бэлтгэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр 10 ААН-д 180, жимсгэнэ, хүнсний ногоо газар тариалангийн чиглэлээр 151 хүнийг ажлын байраар ханган үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>Сэлэнгэ аймгийн Бугантад мод боловсруулах, зүймэл хавтангийн үйлдвэрийг суурилуулан 150 гаруй хүнийг ажлын байраар ханган ажиллаж байна. Мөн суулгац, ногоон төгөл, тохижолт зэрэг нийтийг хамарсан ажилд хүмүүсийг хамруулан Бугант тосгонд 54, Дулаанхаан тосгонд 49, Түнхэл тосгонд 64 ажлын байр бий болгожээ.</p> <p>Булган аймгийн Хялганат тосгонд шахмал түлшний үйлдвэр байгуулан 66 хүнийг ажлын байраар хангаж, 182 га талбайд ойжуулалтын ажил хийж, 30 гаруй иргэдийг ажиллууллаа.</p> <p>Дорнод аймгийн мод бэлтгэн үйлдвэр явуулдаг компаниуд мод бэлтгэж, боловсруулах үйл ажиллагаа явуулж 130 хүнийг түр ажлын байраар хангалаа. Мод боловсруулах, модон бүтээгдэхүүний тавилга хийдэг цех багуулан 6 мужаан, ойн цэвэрлэгээгээр мод бэлтгэх ажилд 30 хүнийг түр ажлын байраар хангаж, сум дундын ойн ангийг байгуулж, үр боргоцой түүх, хавар, намрын тарилт, мод үржүүлгийн газар байгуулах зэрэг ажлуудад давхардсан тоогоор 100, ойжуулалтын ажилд 71 хүнийг түр болон байнгын ажлын байраар хангажээ.</p>								
		<p>Салбарын статистик үзүүлэлт:</p> <p>Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэд мод, модон эдлэлийн үйлдвэрийн бүтээгдэхүүн 2007 онд 0.2, 2008 онд 0.3, 2009 онд 0.25 хувийг тус тус эзэлж байна.</p> <p>Мод, модон эдлэлийн үйлдвэрлэлийн хэмжээ 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2007 онд 2321.6 сая төгрөг болж, өмнөх оныхоос 4.5 хувиар буурсан, 2008 онд 2880.6 сая төгрөг болж, 24 хувиар өссөн бол 2009 оны УГ-ээр 2275.6</p>										

		<p>сая төгрөг болж, урьд оныхоос 21 хувиар буурчээ.</p> <p>- Мод, модон эдлэлийн импорт 2007 онд 12143.0 мянган ам.доллар болж, өмнөх оныхоос 73.3 хувиар, 2008 онд 20286.7 мянган ам.доллар болж, 67 хувиар өссөн бол 2009 оны УГ-ээр 13857.9 мянган ам.доллар болж, 30 орчим хувиар буурчээ.</p> <p>- Мод, модон эдлэл болон мебель тавилга үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний борлуулалт 2007 онд 6371.3, 2008 онд 8712.2, 2009 оны УГ-ээр 7:45.6 сая төгрөг болж, урьд оныхоос 13.4 хувиар буурчээ. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний борлуулалтад эзлэх хувь 2007 онд 0.2, 2008 онд 0.3, 2009 оны УГ-ээр 0.2 хувь хувь болж 0.1 пунктээр буурчээ.</p> <p>- Ажиллагсдын тоо 2006 онд 39.6, 2007 онд 1.6 хувиар буурсан, 2008 онд 13.7 хувиар өссөн бол 2009 оны УГ-ээр 16 хувиар буурчээ.</p> <p>- Хөдөлмөрийн бүтээмж 2006 онд 24.18 хувиар нэмэгдсэн, 2007 онд 4 хувиар буурсан, 2008 онд 30 хувиар өссөн бол 2009 оны УГ-ээр 18.6 хувиар буурав.</p>
8	Хөтөлбөрийн гол үйл ажиллагаа	<p>УИХ-ын 2000 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Ой, мод боловсруулах салбарын үйлдвэрлэлийг сэргээх, тухайн чиглэлээр байгуулагдсан тосгоны хүн амын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлийн дагуу Үйлдвэр, худалдааны сайдын 2007 оны 102 тоот тушаалаар хөтөлбөрийн хоёрдугаар үе шатны (2006-2010 онд) зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж байна.</p> <p><i>Ой, мод боловсруулах үйлдвэрлэлийг сэргээх, хүн амын өргөн хэрэглээний уламжлалт модон эдлэлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх</i> зорилтын хүрээнд:</p> <p>-Засгийн газрын 2009 оны 299 тоот тогтоолоор батлагдсан “Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр”, 178 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл”-д салбарын үйлдвэрлэлийг сэргээх, хөтөлбөрт хамрагдсан тосгодын модны үйлдвэрлэлийг дэмжих сэргээх заалтууд орсон.</p> <p>-2008 онд зохион бйагуулагдсан Үйлдвэрлэл эрхлэгчдийн улсын анхдугаар зөвлөгөөн, “Ой, модны салбарын өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний тухай” асуудлаар нэгдсэн зөвлөгөөн, 2009 онд зохион байгуулагдсан “Мод бэлтгэх болосруулах үйлдэрийн удирдах ажилтны зөвлөлгөөн”-өөр салбарын тулгамдсан асуудлыг хэлэлцэн, зөвлөмж гарган УИХ-ын БОХХААБХ, ЗГХЭГ-г хүргүүлэв.</p> <p>-Мод бэлтгэх, боловсруулах салбарт мөрдөгдөж байгаа болон мөрдөх хугацаа дууссан, шинээр боловсруулан батлуулах шаардлагатай стандартуудын судалгааг гарган, хөтөлбөр боловсруулав. “Мод бэлтгэх, боловсруулах үйлдвэрт тавигдах ерөнхий шаардлага” стандарт, модон материалын нэр томъёоны стандарт, модны согог, гэмтлийн стандарт, мэргэжлийн ажилтан бэлтгэх сургалтын мэргэжлийн стандартууд, модны үр сөөгний төрөл, дээж авах арга, цэвэршилт, соёлолт, амьдрах чадвар, чийг, жинг тодорхойлох 8 стандарт, мод бэлтгэлийн аюулгүй ажиллагааны зааварчилга, шилмүүст болон навчит модон зүсмэл материал, бөөрөнхий модон материал, бэлдэц, согог, бөөрөнхий модон материал, эзлэхүүний таблиц, зүсмэл бүтээгдэхүүн, нэр томъёо, тодорхойлолтын 13 стандартыг боловсруулан батлуулаад байна.</p> <p>- Ойгоос үйлдвэрлэлийн зориулалтаар мод бэлтгэх үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийн хүчин чадлын ашиглалтыг нэмэгдүүлэхийн тулд онд үйлдвэрлэлийн зориулалтаар болон ойн арчилгаа цэвэрлэгээгээр ойгоос бэлтгэх хэрэглээний модны дээд хязгаарыг БОАЖ-ын сайдын тушаалаар жил бүр батлуулан хөтөлбөрт хамрагдсан тосгодын аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжив.</p> <p>-ҮХЯ Сэлэнгэ аймгийн Бугант тосгонд бизнес дэмжих төв байгуулах бэлтгэл ажлыг ханган, салбарын үйлдвэрүүдийн үйл ажиллагааг дэмжих төлөвлөгөө боловсруулан батлуулсан.</p>

	<p>- Ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр Үйлдвэр, худалдааны яам, Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газар, холбогдох Зөвлөл, Арилжааны банкууд хамтран санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэн ЖДҮ-ийг дэмжих сан байгуулснаар жижиг төслүүдийг шалгаруулан мод бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа компаниудад хөнгөлттэй зээл олгох, орон нутгийн төсвийн хөрөнгөнөөс зохих хөрөнгө гаргах арга хэмжээг авсан.</p> <p>- Дархан хотод модон түүхий эдийг иж бүрэн боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цогцолбор байгуулах төсөл боловсруулан, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад танилцуулав.</p> <p>-Аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэлээ өргөтгөх, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх төслийг дэмжин холбогдох банкинд уламжлав. Ойг хамгаалах зохистой ашиглах, нөхөн сэргээх чиглэлээр шинэ дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх 3 төслийг Японы 2 үе шаттай зээлд хамруулахаар сонгон шалгаруулалтад оруулав.</p> <p>ГТХАН-ийн шугамаар Модны салбарт хэрэгжүүлэх төслийн санал боловсруулан Германы талд тавиад байна.</p> <p>- Үйлдвэр технологийн парк байгуулах зорилтын хүрээнд “Барилгын модон хийцийн цогцолбор үйлдвэр”, хөтөлбөр хэрэгжих тосгодоод байгуулах “Мод орлох галд тэсвэртэй хавтангийн үйлдвэр”-үүдийн техник эдийн засгийн үндэслэлийг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж, хэвлүүлэн хэрэглэгчдэд хүргээд байна.</p> <p>- Хялганат тосгонд мод боловсруулах үйлдвэр байгуулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор ДДБТ ХХК-ны Цул хийцийн зүймэл модон хавтан үйлдвэрлэх төслийг ХХААХҮЯ дэмжээд байна. Хялганат тосгонд ойгоос мод бэлтгэгч аж ахуйн нэгжүүдэд байгаль орчинд халгүй аргаар модыг хаягдалгүй туушаар тээвэрлэх дэвшилтэт технологиор үйл ажиллагаа явуулах талаар гэрээ байгуулан хэрэгжүүлэв.</p> <p>- Импортоор орж ирж байгаа мод, модон түүхий эд материалыг НӨАТ-аас чөлөөлөх асуудлаар “НӨАТ-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай” хуулийн төсөл, танилцуулгыг боловсруулсан.</p> <p><i>Ойн санг аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр эзэмшүүлэн ашиглуулж ойнжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээг нэмэгдүүлэх, ойн төрөл бүрийн дагалт баялгийг ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилтын хүрээнд:</i></p> <p>- “Ойн тухай” хуулийг шинэчлэн боловсруулж 2007 онд батлагдсан. Ойн санг аж ахуйн нэгж, байгууллага, нутгийн иргэдийн нөхөрлөлд гэрээгээр эзэмшүүлэх журам”-ыг шинэчлэн мөрдөж байна. Мод бэлтгэх эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр ойгоос мод бэлтгүүлдэг болсон. Ойг хамгаалах нөхөрлөл болон мод бэлтгэх боловсруулах үйлдвэрийг мэргэжлийн удирдлагаар хангах, сум дундын ойн ангийг байгуулахаар дүрэм, холбогдох бусад материалуудыг боловсруулах, байгаль хамгаалагчид болон нутгийн иргэдэд нөхөрлөл байгуулах, ойн санг гэрээгээр эзэмших талаар зөвлөлгөө өгөх арга хэмжээг хэрэгжүүлж байна.</p> <p>- ҮХЯ, Аймаг, Арилжааны банкууд хамтран санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэн ЖДҮ-ийг дэмжих сан байгуулснаар жижиг төслүүдэд хөнгөлттэй зээл олгох арга хэмжээ авч байна.</p> <p>- ГТХАН-ийн “Байгаль хамгаалал, байгалийн нөөцийн тогтвортой менежмент” хөтөлбөрийн дэмжлэгээр “Европ, Хойт Азийн орнуудын Ойн хуулийн хэрэгжилт ба Засаглал”-ын хүрээнд хууль бус мод огтлолттой тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж байна.</p> <p>- Ой, модны эрдэм судлалын төвийг ШУТИС-д шилжүүлэн Ой, модны сургалт судалгааны төв болгон зохион байгуулж, салбарын мэргэжлийн ажилчин ажилтныг мэргэшүүлэх болон мэргэжил эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>- Ой модны сургалт судалгааны хүрээлэнтэй хамтран мод бэлтгэх,</p>
--	--

		<p>боловсруулах үйлдвэрлэл, хэвлэлийн үйлдвэрлэлийн салбарын барааг тодорхойлох, кодлох уялдуусан системийг БТКУС-ийг шинэчлэн боловсруулав.</p> <p><i>Модны үйлдвэрлэлийн чиглэлийн аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байсан хүмүүсийг газар тариалан, мал аж ахуй эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх, бусад үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх үйл ажиллагааг дэмжих</i> зорилтын хүрээнд:</p> <p>- “Атрын III аян” тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр газар эзэмшүүлэн газар тариалан эрхлэх боломжоор ханган, төмс, ногооны үрээр хангах, мэргэжлийн зөвлөлгөө өгөх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэв.</p> <p>-Хөтөлбөрт тусгагдсан тосгодын аж ахуйн нэгж, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж ахуй амьдралыг дээшлүүлэх төсөл боловсруулан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дэмжлэг үзүүлжээ.</p> <p><i>Тосгоны хүн амын нийгмийн асуудлыг сайжруулахад нь дэмжлэг үзүүлэх</i> зорилтын хүрээнд:</p> <p>-Орон нутгийн ЗДТГ-тай хамтран хүн амын нийгмийн асуудлыг сайжруулах талаар арга хэмжээ хэрэгжүүлж байна.</p> <p>-Хялганат тосгоны ЗДТГ төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр “Гэржүүлэх хөтөлбөр”-т 10, “Малжуулах” төсөлд 20 өрхийг тус тус хамруулж, “Тогтвортой амьжиргаа” төслийн 4.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сургуулийн дотуур байрны 80 хүүхдийн гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчилж өгсөн. Ерөнхий боловсролын сургуульд Мэргэжлийн анхан шатны мэдлэг олгох кабинет байгуулж, 3.0 сая төгрөгийн өртөг бүхий багаж, төхөөрөмжөөр хангалаа. Хялганат тосгоны дотуур байр засварлах, хүүхдийн шинэ цэцэрлэг барих, ахмадын сувилалын барилгын барих, эмнэлгийн үйлчилгээг иргэдэд чанартай хүргэх, шинжилгээг богино хугацаанд үнэн зөв гаргах зорилгоор лабораторийн анхан шатны багаж тоног төхөөрөмж, “ЭХО” аппаратаар тоноглох зэрэгт хөрөнгө хийжээ. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, амьжилгааг дээшлүүлэх ажлын хүрээнд тосгоны 22 өрхийг ядуурлаас гаргахаар тусган төлөвлөж, нийтийг хамарсан ажилд 12, Төрийн бус байгууллага болон төсөл хөтөлбөрт 3, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сургалтанд 1, хоол хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрт 4 өрхийг хамруулсан байна.</p> <p>-Тосонцэнгэл суманд Тогтвортой амжиргаа төсөл, Дэлхийн зөн ОУБ, Мерси корпус, ЖДҮД Сан, ХАҮТэнхим зэрэг байгууллагууд мэргэжлийн чиглэлүүдээр сургалт зохион байгуулж иргэдийг олноор хамруулж ажилласан.</p>
9	<p><i>Дүгнэлт /ололт, дутагдал, анхаарах асуудлууд/</i></p>	<p>Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг удирдлага болгож ХҮБХЗГ-аас гаргасан уг хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, холбогдох статистик мэдээллүүдийг үндэслэн Үйлдвэр, худалдааны сайдын 2007 оны ... тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан «Оой, мод боловсруулах салбарын үйлдвэрлэлийг сэргээх, тухайн чиглэлээр байгуулагдсан тосгоны хүн амын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний хөтөлбөр”-ийн 2 дугаар үе шатны зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний 2007 – 2010 оны төлөвлөгөө”-ний арга хэмжээ бүрийн хэрэгжилтийг дүгнэн хийв.</p> <p>Энэ хөтөлбөрийн хоёрдугаар үе шатанд “Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл”-д тусгагдсан 4 зорилтын 16 арга хэмжээ төлөвлөгджээ. Уг шатны арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явц 2009 оны жилийн эцсийн байдлаар дунджаар 75 хувьтай дүгнэгдэж байна.</p> <p>Хөтөлбөрт заагдсан тосгодод ажиллаж байгаа модны үйлдвэрүүдийн хэвийн үйл ажиллагааг ханган, хүчин чадлын ашиглалтыг нэмэгдүүлэх, шинэ технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх төсөл, арга хэмжээг</p>

	<p>хөнгөлөлттэй зээл, тусламжид хамруулах замаар хэрэгжүүлж шинэ ажлын байр бий болгох зорилтын хэрэгжилт тодорхой үр дүнд хүрчээ.</p> <p>Ойгоос үйлдвэрлэлийн зориулалтаар мод бэлтгэх үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүд БОЯмнаас өгсөн зөвшөөрлийн дагуу үйлдвэрлэлийн зориулалтаар болон ойн арчилгаа цэвэрлэгээгээр ойгоос 2006 онд 30, 2007 онд 61, 2008 онд 150.0 мян шоометр мод, 2009 онд урьд оныхоос 2-3 дахин ихийг бэлтгэсэн.</p> <p>Үйлдвэржүүлэлтийг дэмжих жилийн хүрээнд 2009 онд улсын төсвийн хөрөнгийн дэмжлэг болон бусад эх үүсвэрээр 2307,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг мод боловсруулах салбарын 70 гаруй аж ахуйн нэгжүүдэд хийснээр Улаанбаатар хот, орон нутагт цэвэршүүлсэн зүймэл модон хавтан, модон савх, мод хатаалга, модон вакум цонх хаалга, модны үртэс, зоргодос, чавчдас хатаан механикаар шахаж брикетэн түлш үйлдвэрүүдэд 100 ажлын байр шинээр бий болгов.</p> <p>Газар тариалан эрхлэх сонирхолтой иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр газар эзэмшүүлэн газар тариалан эрхлэх болсон. Сэлэнгэ аймгийн Дулаанхаан, Бугант, Түнхэл тосгодоод хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалуулах замаар 70 иргэнд 25,5 га газар олгон төмс, ногооны үрээр ханган, мэргэжлийн зөвлөгөө өгөв. Тосонцэнгэл суманд тариалан эрхэлдэг иргэд, аж ахуйн нэгжийн тоо жилээс жилд нэмэгдэж байна. Хялганат тосгонд газар тариалан эрхлэх сонирхолтой иргэдийн сургалтын “загвар аж ахуй” байгуулах зориулалтаар 2 га газар олгосон. Дорнод аймгийн хэмжээнд модны үйлдвэрлэл эрхлэж байсан Баян-Уул сумын иргэд өрхийн тариалан эрхлэхээс гадна, 13 аж ахуйн нэгжид төмс, хүнсний ногоо тариалж байна. Баян-Уул сумын хэмжээнд өрхийн тариалан эрхлэх хүсэлт гаргасан иргэдэд 23 га газар олгожээ.</p> <p>Дархан хотод модон түүхий эдийг иж бүрэн боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цогцолбор байгуулах, аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэлээ өргөтгөх, ойг хамгаалах зохистой ашиглах, нөхөн сэргээх чиглэлээр шинэ дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, шинэ нэр төрлийн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх төслүүдийг хөнгөлөлттэй зээлд хамруулахаар гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад танилцуулж байгаа ч тодорхой үр дүн гараагүй байна.</p> <p>Манай барилгын салбарт мод эрэлт хэрэгцээ ихтэй байна. Дэлхийн банкнаас явуулсан судалгаанаас үзвэл, манай орны модон түүхий эд материалын дотоод зах зээлийн хэрэгцээний хангалтын ихэнх хэсгийг хууль бусаар бэлтгэсэн мод эзэлдэг байна. ГТХАН-ийн “Байгаль хамгаалал, байгалийн нөөцийн тогтвортой менежмент” хөтөлбөрийн дэмжлэгээр “Европ, Хойт Азийн орнуудын Ойн хуулийн хэрэгжилт ба Засаглал”-ын хүрээнд хууль бус мод бэлтгэл, ойн бусад гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, холбогдох баримт бичгүүдийг боловсруулах ажлыг эрчимжүүлэх нь чухал.</p> <p>Албан ёсны статистик мэдээгээр мод, модон эдлэлийн үйлдвэрлэлийн хэмжээ буурч, мод, модон эдлэлийн импорт өсөх хандлагатай байна. 2006 - 2007 онуудад ажиллагсдын тоо, хөдөлмөрийн бүтээмж буурч, 2008 онд бага хэмжээгээр өссөн бол 2009 онд буурсан байна. Эндээс үзэхэд мод, модон эдлэл үйлдвэрлэлийн гол үзүүлэлт тогтвортой бус эерэг, сөрөг хэлбэлзэлтэй байгааг харгалзан, ойгоос бэлтгэх мод, модон бүтээгдэхүүний зах зээлийн бодит хэрэгцээ, эрэлт, ойгоос бэлтгэх модны дээд хязгаарын зөвшөөрөл, техник, технологийн шинэчлэлтийн талаар судалгаа хийх, төсөл хэрэгжүүлэх шаардлагатай байна.</p> <p>Ойг ашиглах, хамгаалах тогтвортой менежмент байхгүй байгаа нь ойгоос мод бэлтгэх, ойг нөхөн сэргээх, мод боловсруулах үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлж байна. Ойн түймэр ба ойн хортон шавьж нь ойгоос мод бэлтгэж ашиглахаас ч илүү хохирол учруулсаар байна.</p>
--	--

10	<i>Хүлээгдэж буй үр дүндээ хүрээгүй бол шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлс</i>	Хөтөлбөрийн үйлдвэрүүдийн санхүү, эдийн засгийн чадавхийг сайжруулж, тогтвортой ажиллагааг хангах, шинэ технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх зорилтын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд зарцуулагдах хөрөнгийн эх үүсвэр батлагдаагүй.
11	<i>Эдгээрээс гарах арга зам</i>	<ul style="list-style-type: none"> - Мод, модон бүтээгдэхүүний зах зээлийн бодит хэрэгцээ, эрэлт, салбарын үйлдвэрүүдийн хүч чадлын ашиглалт, техник, технологийн шинэчлэлтийн талаар судалгаа явуулж, салбарын тогтвортой хөгжлийн стратегийг боловсруулан хэрэгжүүлэх, - Ойн баялгийг гал түймэрт өртөх, хортон шавьжинд идэгдэх, хууль бус мод бэлтгэхээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр холбогдох байгууллагатай хамтран боловсруулан хэрэгжүүлэх, - Аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэлээ өргөтгөх, ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх чиглэлээр дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, шинэ нэр төрлийн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх төслүүдийг хөнгөлөлттэй зээлд хамруулах арга хэмжээг үр дүнд хүргэх, - Ойн нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, мод бэлтгэх зөвшөөрөл олгохдоо ААН-д тавих шалгуурыг нарийвчлах, хяналт, зохицуулалт хийх, - Хөтөлбөрийг хэрэгжилтэд шаардагдах санхүүжилтийг цаг хугацаанд гаргуулах асуудлыг холбогдох газарт хүргүүлэн дэмжлэг авах.
12	<i>Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын талаархи үнэлгээ</i>	Монголын ойчдын нэгдсэн холбоо, ХХААХҮЯ-ны хамтын ажиллагаа нь “сайн” байна.
13	<i>Хөтөлбөрийн талаархи яамны санал</i>	<ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрийг үргэлжүүлэн хэрэгжүүлэх, үйл ажиллагааг эрчимжүүлэх, - Ойн баялгийг гал түймэрт өртөх, хортон шавьжинд идэгдэх, хууль бус мод бэлтгэхээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр холбогдох байгууллагатай хамтран боловсруулан хэрэгжүүлэх,

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Т.ГАНТУЛГА